

Кассын гүйлгээний дүн болон бараа материалын борлуулалтын дүнгүүд нь заавал таарах албагүй дүнгүүд юм. Учир нь кассын гүйлгээний тайлан нь тайлангаас тайлангийн хооронд буюу нэг тайлан авсан хугацаанаас хойш дараагийн тайлан авсан хугацааны хооронд үзүүлж байгаа дүн юм. Кассын гүйлгээний тайланг хэдэн цаг хэдэн минутаас авсан болон хэдэн сарын хэдний өдрөөс хэдэн сарын хэдний өдрийн хоорондох дүн бэ гэдэг нь маш чухал.

Кассан дээрээс F6 тайланг хэзээ авсан яг тухайн цаг хугацаанд кассын гүйлгээний тайлан үүснэ. Энэ нь кассын тайлан буюу бэлэн мөнгөний тайлан юм. Харин борлуулалтын тайлан нь кассаас тайлан авсан аваагүй хамаагүй барааг худалдаалсан л бол үүсдэг тайлан юм. Борлуулалтын тайлан нь хайлт хийх хугацааны хамрах хүрээ нь өмнөх өдрийн 00.00 цагаас дараа өдрийн 00.00 цагын хоорондох борлуулалтын мэдээг танд шүүж үзүүлнэ. Гэтэл кассын борлуулалтын тайлан бол тайланг авахад үүссэн дугаараар шүүж үзүүлэх бөгөөд энэ хоёр тайлан нь хамрах хугацааны хувьд цаг болон минутын зөрүү байх бөгөөд тухайн хугацааны зөрүүнд хамаарах борлуулалтын дүнгээр зөрнө.

Мөн янз бүрийн шалтгаанаар кассын компьютерийн цаг хугацаа нь бодит цагаас зөрөх тохиолдол байдаг. Тухайн касс дээр он сан өдөр өөрчлөгдсөн үед хийгдсэн борлуулалт нь касс дээр бараа зарагдах үед ямар он, сар, өдөр цаг минут байсан яг тэр огноог авч борлуулалтын тайланд нэмэгддэг. Жишээ нь кассын машины хугацаа 2012 оны 10 сарын 26-ны өдөр 14.00 гэсэн хугацааг зааж байх үед борлуулсан барааг нь борлуулалтын тайлангаас шүүхэд 2012 оны 10 сарын 26 нд борлуулсан байна гэж танд шүүж үзүүлнэ. Гэтэл бодит цаг хугацаа нь 2016 оны 10 сарын 26 байсан бол энэ хугацааны

борлуулалтын тайланд огноо өөрчлөгдсөн үед зарагдсан барааны борлуулалтын дүн харагдахгүй байна гэсэн үг юм. Харин огноо өөрчлөгдсөн үед борлуулагдсан барааны дүн нь F6 тайлан буюу кассын гүйлгээний тайлангын дүнд орсон байна.

Кассын гүйлгээний тайлан нь тайлан авснаас хойш борлуулсан бараа ажил үйлчилгээний дүнг хадгалах учир кассын машин дээр огноо өөрчлөгдөн ч гэсэн тухайн тайланд дүн нь орох учир нэмж хадгалдаг гэсэн үг юм. Дээрх тохиолдлуудаас хамааран тухайн 2 тайлангийн дүнгүүд зөрнө.